



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын аялал жуулчлалын
сурталчилгааг эрчимжүүлэх зарим
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, Засгийн газрын 2019 оны 333 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09, 02/10 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/493 дугаар захирамж, Газрын 2022 оны дүрмийн 4.1.3, 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Улаанбаатар хотын онцлог бүхий брэндийг хөгжүүлж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, аялал жуулчлалын маркетинг сурталчилгааны ажлыг зохион байгуулсугай.

2. Маркетинг сурталчилгааны ажлыг зохион байгуулахад шаардагдах хавсралтад заасан 89 000 000 /наян есөн сая/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Өнөржаргал/-д зөвшөөрсүгэй

3. Тушаалын хэрэгжилтэд хяналтад тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга /В.Батчимэг/-т даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ



115-539962

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2022 оны 07 сарын 19 өдрийн
А/18 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



УЛААНБААТАР ХОТЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СУРТАЛЧИЛГААГ
ЭРЧИМЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙГ ЗОХИОН .
БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

2022 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Улаанбаатар хотын онцлог бүхий брэндийг хөгжүүлэх зардал /Ulaanbaatar brand/	1	20 000 000	20 000 000
2	Аялал жуулчлалын сурталчилгааны цахим танилцуулга, контент бэлтгэж, гадаад дотоодод сурталчлах зардал	2	16 000 000	16 000 000
3	Аялал жуулчлалын гадаад сурталчилгааны цахим платформ жуулчдад зориулсан цахим сайтыг хөгжүүлэх зардал	4	13 000 000	13 000 000
4	Улаанбаатар хотын гудамж талбайн газрын зургийг "2D illustration map" хэлбэрээр гаргах зардал	10	2 000 000	20 000 000
5	Улаанбаатар хотын газрын зургийг дрон болон архитектур гэрэл зурагт оруулах ажлын зардал	10	2 000 000	20 000 000
НИЙТ				89 000 000

-оо0оо-